



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

“Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх, “ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгэх түр журам”-ыг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, Засгийн газрын 2016 оны 103 дугаар тогтоол, 2019 оны 282 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам”-ын 2.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 126 дугаар тогтоолоор батлагдсан “Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм”-ийн 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх “ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгэх “түр журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Дээрх журмыг нийт төлбөр авах цэгийн ахлагч нарт танилцуулан, журмын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Төлбөр авах үйл ажиллагааны хэлтэс (Б.Энхбаатар)-т даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан төвийн захирлын 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/115 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Б.Батсайхан)-т тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ



Х.ПҮРЭВЖАРГАЛ

Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирлын
2023 оны 1 дугаар сарын 13 -ний өдрийн
...../13/ дугаар тушаалын хавсралт



**Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам,
замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх,
“ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгэх түр журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгслийг “ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгэх, бүртгэлээс хасах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. “ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгүүлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Засгийн газрын 2016 оны 103 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2019 оны 282 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам”-аар зохицуулагдана.

Хоёр. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх, “ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгэх

2.1. Албан үүргээ гүйцэтгэж яваа Замын хөдөлгөөний аюугүй байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т заасан тээврийн хэрэгсэл нь Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөнө.

2.2. “Чингис хаан” ОУНБ-д үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, Эмээлт, Хоолт, Налайх, Түргэний гүүрийн төлбөр авах цэгүүдээр зорчихоор хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын хүсэлтийг судалж энэхүү журмын хүрээнд “ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгэнэ.

2.3. “ЦАГААН ЖАГСААЛТ”-д хамрагдах хүсэлтийг WWW.ROADPAY.MN бүртгүүлэн холбогдох материалыг илгээн баталгаажуулах, тогтоосон хугацаанд холбогдох тайланг үндэслэн баталгаажуулан сунгана.

2.4. “ЦАГААН ЖАГСААЛТ”-д хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд гэдэгт нийслэл хотыг тойрсон Эмээлт, Налайх, Хоолт, Түргэний гүүрийн төлбөр авах цэг байрлах тухайн дүүрэг хороодод ажиллаж, амьдардаг иргэн, үйл ажиллагаа эрхлэн явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдүүдийг хэлнэ.

2.4.1. Үйл ажиллагаа эрхлэн явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийн ажилтны тээврийн хэрэгслийг Эмээлт, Хоолт, Налайх, Түргэний гүүрийн төлбөр авах цэгүүдээр зөвхөн ажилдаа ирэх, буцах зорилгоор зорчсон төлбөрийг энэхүү журамд заасны дагуу чөлөөлнө.

2.5. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх, “ЦАГААН ЖАГСААЛТ”-д хамрагдах иргэнийг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын хариуцсан албан тушаалтан бүртгэн баталгаажуулна.

Гурав. Баримт бичгийн бүрдүүлэлт

3.1. Энэ журмын 2.2-т заасан Аж ахуй нэгж, байгууллага, хуулийн этгээд болон түүний ажилтнууд нь “ЦАГААН ЖАГСААЛТ”-д шинээр бүртгэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.1.1. Олон улс, улсын чанартай авто замын дагуух төлбөр авах цэгээр нэвтрэх “ЦАГААН ЖАГСААЛТ”-д хамрагдахыг хүссэн маягт;

3.1.2. Байгууллагын гэрчилгээний хуулбар;
3.1.3. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар;
3.1.4. Тээврийн хэрэгслийн нэвтрэх зөвшөөрлийн тооцооны хүснэгт маягт; /Жил бүрийн 12 сард шинэчлэн өгөх/

3.1.5. Бусад холбогдох бичиг баримт; /Нийгмийн даатгалын лавлагаа сүүлийн 3 сар, үйл ажиллагаа явуулж буй байршлыг тодорхойлох баримт бичиг, түрээсийн гэрээ гэх мэт/

3.2. тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны тээврийн хэрэгслийн төлбөр авах цэгээр нэвтрэлтийн зөвхөн ажилдаа ирэх, буцах авто зам ашигласны төлбөрийг чөлөөлөх бөгөөд бусад нэвтрэлтийн төлбөрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд эсхүл ажилтан хариуцна.

3.3. Энэ журмын 2.2-т заасан иргэн нь “ЦАГААН ЖАГСААЛТ”-д шинээр бүртгэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.3.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах цэгээр нэвтрэх “ЦАГААН ЖАГСААЛТ”-д хамрагдахыг хүссэн маягтыг хавсралтад заасны дагуу бөглөж ирүүлнэ.

3.3.2. Иргэний үнэмлэхийн хуулбар, /Оршин суугаа хаягын цахим тодорхойлолт/

3.3.3. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар /тухайн иргэний эзэмшилд байх ба тухайн тээврийн хэрэгсэл нь Банк, банк бус нэр дээр бол зээлийн гэрээний хуулбар, бусад нотлох баримтын хамт/

3.3.4. Бусад холбогдох бичиг баримт;

Дөрөв. Шилжилт хөдөлгөөнийг бүртгэх

4.1. Энэ журмын 2.2-т заасан харьяаллын дагуу “ЦАГААН ЖАГСААЛТ”-ын бүртгэлийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэхдээ дараах баримт бичгийг үндэслэнэ:

4.1.1. Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, байршил өөрчлөгдсөн тохиолдолд албан бичгээр гаргасан хүсэлт;

4.1.2. “ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгэлтэй тээврийн хэрэгслийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд журмын 3 дахь хэсэгт заасан баримт бичиг;

4.1.3. Тээврийн хэрэгслийн гэрчилгээнд өөрчлөлт орсон бол хуулбар;

4.2. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг “ЦАГААН ЖАГСААЛТ”-ын тогтоосон хугацааны хяналт, шалгалтыг үндэслэн энэ журмын 5 дахь хэсэгт заасны дагуу холбогдох арга хэмжээг авна.

Тав. “ЦАГААН ЖАГСААЛТ”-ын бүртгэлээс хасах

5.1. “ЦАГААН ЖАГСААЛТ”-ын бүртгэлээс хасахдаа дараах баримт бичгийг үндэслэн дараах тохиолдолд бүртгэлийн сангаас шууд хасна. Үүнд:

5.1.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь “ЦАГААН ЖАГСААЛТ”-ын бүртгэлээс хасалт хийлгэх тухай албан хүсэлт; /Тээврийн хэрэгслийн улсын дугаар, жолоочийн овог нэрийг тодорхой бичнэ/

5.1.2. Тээврийн хэрэгслийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд;

5.1.3. Тухайн тээврийн хэрэгсэл эзэмшигчийн харьяалал өөрчлөгдсөн тохиолдолд;

5.1.4. “ЦАГААН ЖАГСААЛТ”-ын бүртгэлийн мэдээлэл, холбогдох тайланг мэдүүлээгүй.

Зургаа. Хяналт тавих

6.1. “ЦАГААН ЖАГСААЛТ”-ын бүртгэл, судалгаа хийх ажлыг Төлбөр авах үйл ажиллагааны хэлтэс хариуцан зохион байгуулна.

6.2. Олон улс, улсын чанартай авто замын дагуух төлбөр авах цэгээр нэвтрэх жагсаалтад хамрагдсан иргэн, аж ахуй нэгж байгууллагын тээврийн хэрэгслийг бүртгэн нэвтрүүлэх үйл ажиллагааг Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн Мэдээллийн технологи хариуцсан ажилтан дээд шатны удирдах албан тушаалтнаар хянуулан баталгаажуулна.

6.3. “ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ, мэдээлэл, холбогдох тайланг тогтоосон хугацаанд WWW.ROADPAY.MN цахим хаягаар хүлээн авч, хяналт тавьж ажиллана.

Долоо. Хариуцлага

7.1. “ЦАГААН ЖАГСААЛТ”-д бүртгэх бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн бол жагсаалтаас тухайн тээврийн хэрэгслийг хасаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

7.2. Мэдээллийн технологи хариуцсан ажилтан нь албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн болон бусдын ашиг сонирхлын өмнөөс албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хэтрүүлэхгүй байна.

7.3. Зохих зөвшөөрөл, шийдвэргүйгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгслийг энэхүү журмыг зөрчсөн, “ЦАГААН ЖАГСААЛТ”-ын бүртгэлд оруулсан, өөрчлөлтийг дур мэдэн хийсэн, нотлох баримт бичгийг үндэслээгүй эсхүл өөрчлөлт хийхгүйгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэл учруулсан ажилтанд “Хөдөлмөрийн тухай” хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баримтлан эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

7.4. Олон улс, улсын чанартай авто замын дагуух төлбөр авах цэгээр нэвтрэх цагаан жагсаалтад хамрагдсан тээврийн хэрэгслийн эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тээврийн хэрэгслийн мэдээллийг шинэчлээгүй, төлбөрөөс чөлөөлөгдөх харьяалалд хамаарахгүй болсон, журамд зааснаас бусад тохиолдлоор өөрчлөгдсөнөөс үүдэн гарсан төлөгдөөгүй төлбөрийн нэхэмжлэхийг хариуцах бөгөөд нөхөн барагдуулна.

...ооо...

Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх, "ЦАГААН ЖАГСААЛТ"-д бүртгэх түр журмын хавсралт

20... оны дугаар сарын өдөр

Улаанбаатар хот

Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр цэгээр нэвтрэх зөвшөөрөл хүссэн маягт

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/116 дугаар "Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын "Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх, "ЦАГААН ЖАГСААЛТ"-д бүртгэх түр журам"-ын дагуу аймаг, нийслэл сум, дүүргийн дугаар баг, хорооны байр, гудамжны тоотод оршин суугч /албан байгууллага, иргэн/-ийн нь /РД...../.....төлбөр авах цэгээр /тээврийн хэрэгслийн дугаар/ /марк/ тээврийн хэрэгслээр нэвтрэх хүсэлтэй байгаа тул "ЦАГААН ЖАГСААЛТ"-д бүртгэж өгнө үү.

Хүсэлт гаргасан:

...000...